



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар Б/165

Хэрлэн сум

Б.Лхагвасамбууг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.2.2, 9.2.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, Засгийн газрын 1999 оны "Цэргийн цолны цалингийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 38 дугаар тогтоол, Засгийн газрын 2004 оны "Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам" батлах тухай 123 дугаар тогтоол, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/553 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ахлах дэслэгч Буянбатын Лхагвасамбууг Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицeroор 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын

дарга: Н.Хүрэлээ Цэргийн штабын дарга, Хурандаа

Гишүүд: Б.Дарханбаатар Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Т.Баяртуяа Нярав

3. Б.Лхагвасамбуугийн цалинг ТТ-4 зэрэглэлээр тогтоон, үндсэн цалин 1,622,000 (нэг сая зургаан зуун хорин хоёр мянга) төгрөгөөр, цэргийн цолны цалинг 28 хувиар, удаан жил ажилласны нэмэгдлийг 5 хувиар, онцгой нөхцөлийн нэмэгдлийг 10 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Б.Лхагвасамбууг томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА